

## ТАНИЛЦУУЛГА

Хүнсний барааны үнийн 2017 оны 2-р сарын 08-ний өдрийн ажиглалт

Нийслэлийн төвийн 6 дүүрэгт байрладаг 12 хүнсний зах, худалдааны төвд хийсэн 33 нэр төрлийн хүнсний бараа бүтээгдэхүүний үнийн 2017 оны 2-р сарын 2-р долоо хоногийн ажиглалтаар өмнөх долоо хоногоос 22 нэрийн барааны үнэ **тогтвортой**, 2 нэрийн барааны үнэ **буурсан**, 9 нэрийн барааны үнэ **өсчээ**. Үүнд :

## ≈ Үнэ тогтвортой

- "Алтан Тариа" задгай гурил дээд
- "Алтан Тариа" задгай гурил I
- "Алтан Тариа" савласан гурил дээдийн дээд
- "Алтан Тариа" савласан гурил дээд
- "Алтан Тариа" савласан гурил I
- "Алтан Тариа" савласан гурил II
- "Алейка" гурил дээд
- "Сүү" ХК хайрцагтай 1 л сүү
- Сүү, задгай
- Талх, "Атар"
- Талх, "Зууван чех"
- Цагаан будаа
- Шар будаа
- Цөцгийн тос, Сүү ХК
- Ургамлын тос
- Ногоон цай, "Гүрж"
- Элсэн чихэр
- Адууны мах, ястай
- Ямааны мах, ястай
- Сонгино, хятад, бөөрөнхий
- Алим, фүжи
- Өндөг, ОХУ

## ↓ Үнэ буурсан

- Лууван, монгол
- Хүрэн манжин, монгол


## ↑ Үнэ өссөн

- "Сүү" ХК савласан 0.5 л сүү
- Тараг, Цөцгийтэй
- Талх, "хөх тарианы хар"
- Хонины мах, ястай
- Хонины мах, цул
- Үхрийн мах, ястай
- Үхрийн мах, цул
- Төмс, монгол
- Байцаа, монгол

## Махны дундаж үнэ

2017 оны 2-р сарын 2-р долоо хоногт хонины ястай нэг килограмм мах дунджаар 6015 төгрөг, үхрийн ястай мах нэг килограмм нь дунджаар 7470 төгрөгийн үнэтэй байна. Үхрийн ястай махны үнэ өмнөх долоо хоногтой харьцуулахад 7.1 хувиар буюу 495 төгрөгөөр, үхрийн цул махны үнэ 3.2 хувиар буюу 265 төгрөгөөр өссөн байна. Энэ 7 хоногийн ажиглалтаар үхрийн мах "Хархорин" хүнсний захад хамгийн хямд буюу 7200 төгрөг, харин "Бөмбөгөр", "Меркури", "Таван-Эрдэнэ" хүнсний захуудад хамгийн өндөр үнэтэй буюу 8000 төгрөг байна.

Зураг 1. Үхрийн 1 кг махны дундаж үнэ, төгрөг



Хүснэгт 1. Нэг килограмм махны жижиглэн худалдах дундаж үнэ, 2013-2017 оны сар, төгрөг

Үхрийн мах												
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2013 он	7335	8025	7895	8330	8380	8275	8225	7710	7825	7245	7115	7280
2014 он	7980	7775	8425	8370	8685	8730	7955	7590	7635	7550	7495	7465
2015 он	7415	7565	7810	8080	8145	8445	7985	7230	7005	5975	5620	5520
2016 он	6165	6875	7105	8170	8495	7930	6950	6865	6120	5235	5495	5580
2017 он	6775	7470*										
Хонины мах												
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2013 он	6480	7095	7060	7420	7490	7470	7415	6710	6540	6215	6085	6245
2014 он	6855	6675	7040	7630	7800	7685	7030	6585	6395	5965	5835	5940
2015 он	5860	6140	6735	7460	7555	7455	6830	6050	5540	4510	4200	3930
2016 он	4625	5495	5970	6935	6945	6525	5780	5605	4940	4250	3945	4390
2017 он	5650	6015*										

\* 2-р долоо хоногийн ажиглалтаар

Зураг 2. Хонины 1 кг махны дундаж үнэ, төгрөг



Хонины ястай махны үнэ өмнөх долоо хоногтой харьцуулахад 4.2 хувиар буюу 240 төгрөгөөр, хонины цул мах 1.1 хувиар буюу 70 төгрөгөөр тус тус өссөн байлаа. Энэ долоо хоногийн ажиглалтаар хонины мах "Баянзүрх", "Хүчит Шонхор", "Хархорин" хүнсний захуудад хамгийн хямд буюу 5200 төгрөгөөр, харин "Меркури" хүнсний захад хамгийн өндөр үнэтэй буюу 7500 төгрөгөөр худалдаалж байна.


## Гурилын үнэ




2017 оны 2-р сарын 2-р долоо хоногт нийслэлийн хүнсний томоохон зах, дэлгүүрт "Алтан тариа" савласан нэг кг гурилын үнэ дээд зэрэг нь 1200-1500 төгрөг, 1-р зэргийнх 1000-1300 төгрөг, 2-р зэргийнх 800-900 төгрөг байна.

Худалдан авагч олон байдаг "Хүчит шонхор", "Таван эрдэнэ", "Бөмбөгөр", "Баянзүрх", "Хархорин" хүнсний захуудад задгайгаар буюу шуудайгаар худалдаж буй нэг кг дээд зэргийн "Алтан тариа" гурилын үнэ 1150-аас 1300 төгрөгийн үнэ ханштай байна. Харин "Барс" хүнсний захад дээд зэргийн "Алтан тариа" гурил 1100 төгрөг, 1-р зэргийн гурил 950 төгрөгөөр тус тус зарагдаж байна.

Зураг 3. Дээд зэргийн 1 кг гурилын үнэ, төгрөг



Зураг 4. Савласан 1 кг гурилын үнэ, төгрөг



“Атар” талх хүнсний зах, дэлгүүрт 1100-1210 төгрөгийн үнэтэй байна. “Бөмбөгөр”, “Барс”, “Оргил”, “Хархорин” хүнсний захуудад “Атар” талхыг хамгийн хямд буюу 1100 төгрөгөөр, харин “Сансар” супермаркетэд хамгийн өндөр үнээр буюу 1210 төгрөгөөр худалдаалж байна.



Сар шинийн баярын ширээний ууцны дундаж үнэ 197500 төгрөг байна. 2016 оны сар шинийн баярын өмнөх үеэс ууцны үнэ 3.7 хувиар буюу 7500 төгрөгөөр буурсан байна.

Овор хэмжээ бага ууцыг “Хүчит Шонхор” зах дээр 120000-150000 төгрөг, дунд хэмжээний ууцыг 180000-200000 төгрөг, том овор хэмжээтэй ууцыг 250000-300000 төгрөгөөр тус тус худалдаж байна.



Цагаан сарын баярын ширээний тавгийн гол идээ болох хэвийн боовны үнэ нэг ширхэг нь дунджаар 2063 төгрөг байна.

Хамгийн хямд үнэтэй хэвийн боов нь “Өгөөж” үйлдвэрийнх, хамгийн өндөр үнэтэй нь “Бамбууш” үйлдвэрийнх байна. Хэвийн боовны үнийн ялгаа нь харагдах өнгө зүс, амт, чанараас шалтгаалж байв. 2016 оны цагаан сарын баярын өмнөх үеэс хэвийн боовны үнэ 5.2 хувиар буюу 103 төгрөгөөр өссөн байлаа.

Хүснэгт 2. Хэвийн боовны дундаж үнэ, төгрөг, 2012-2017 оноор

	2012 он 02.15	2013 он 01.30	2014 он 01.22	2015 он 02.11	2016 он 01.27	2017 он 02.08
Ширхэг	1535	1972	2035	2120	1960	2063
15 ширхэг	22314	29579	30525	31800	29404	30938
21 ширхэг	32240	41410	42735	44520	41165	43313

## Хүснэгт 3. Ууцны дундаж үнэ, төгрөг, 2012-2017 оноор

Үнийн хязгаар	2012 он 02.15	2013 он 01.30	2014 он 01.22	2015 он 02.11	2016 он 01.27	2017 он 02.08
Дээд	213500	283333	400000	315000	260000	275000
Доод	127700	100000	125000	145000	150000	120000

**Төмс, хүнсний ногоо**

Зураг 5. Нэг кг хүнсний ногооны дундаж үнэ, төгрөг

2017 оны 2-р сарын 2-р долоо хоногт өмнөх долоо хоногтой харьцуулахад монгол төмс 1.4 хувиар буюу 10 төгрөгөөр, байцаа 11.3 хувиар буюу 130 төгрөгөөр өсч, харин лууван 0.5 хувиар буюу 5 төгрөг, хүрэн манжин 2.3 хувиар буюу 35 төгрөгөөр тус тус буурсан байна.

**Хэрэглээний үнийн ажиглалтын хавсралт хүснэгт:**

Хавсралт 1. Хүнсний барааны үнийн ажиглалт, хүнсний зах, худалдааны төвөөр, 2017.02.08

Хавсралт 2. Хүнсний барааны дундаж үнийн зэрэгцүүлэлт, 2016 оны 11, 12-р сар, 2017 оны 1, 2-р сар

Хавсралт 3. Хүнсний барааны дундаж үнийн зэрэгцүүлэлт, 2011-2017 оны 2-р сарын 08

Хавсралт 4. Хэвийн боов, хонины ууцны дундаж үнэ, 2017.02.08

Хавсралт 5. Шатахуун, түлшний үнэ, ШТС-аар, 2017.02.08

Хавсралт 6. Шатахууны үнийн зэрэгцүүлэлт, 2016 оны 11, 12-р сар, 2017 оны 1, 2-р сарын ажиглалтаар

Хавсралт 7. Шатахууны үнэ өөрчлөгдсөн өдөр, 2014-2017 он

Хавсралт 8. Түлшний дундаж үнэ, худалдаж буй байршлаар, 2017.02.08